

“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ЫН
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

➤ Үнэлгээний аргачлал	3
➤ Үнэлгээний нэгдсэн дүн	4
➤ Үнэлгээний дэлгэрэнгүй тайлан	5-13
➤ Нотлох баримтын жагсаалт	14
➤ Хавсаргасан нотлох баримтууд	15

ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Санхүүгийн зохицуулах хорооноос шинэчлэн баталсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний аргачлалын дагуу Дархан нэхий ХК-ийн ТУЗ үнэлсэн үнэлгээний үр дүнг, Санхүүгийн зохицуулах хороо 2024 оны 8 сард хянан баталгаажуулсан болно.

Үнэлгээний асуулгын бүтэц.

1. ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт
2. ТУЗ-ийн дэргэдэх хороод тэдгээрийн чиг үүрэг
3. Тайлагнал, мэдээллийн ил тод байдал
4. Аудит хяналтын тогтолцоо
5. Эрсдлийн удирдлага
6. Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал
7. Оролцогч талуудын эрх ашиг
8. Компанийн соёл
9. Хувьцаа эзэмшигчдийн эрх гэсэн 9 үндсэн үзүүлэлт бүхий 36 асуулгаас бүрдсэн

Үнэлгээний оноо

Асуулга тус бүрийн хүрээнд хийгдвэл зохих ажлын хэрэгжилтийг 0-2 оноогоор үнэлж түүнийгээ хувьд шилжүүлэн, Үнэлгээг 0-100 хувиар тооцож гаргасан болно.

- Бүрэн хэрэгжүүлсэн, эсвэл үндэслэл бүхий тайлбар гаргасан бол 2 оноо
- Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилтоо тайлбарласан бол 1 оноо
- Хэрэгжүүлээгүй, үнэлгээ ирүүлээгүй бол 0 оноо

Нэгдсэн үнэлгээ

Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараахь байдлаар үнэлнэ.

- Авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш бол засаглал хэвийн буюу эрсдэлгүй;
- 70-89 хувь бол дунд засаглалтай, цаашид эрсдэл үүсч болзошгүй тул Монголын хөрөнгийн бирж зөвлөмж хүргүүлэх;
- 50-69 хувь бол хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул Хөрөнгийн биржээс зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
- 49 болон түүнээс доош бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай гэж үзнэ.

ҮНЭЛГЭЭ НЭГДСЭН ДҮН

“Дархан нэхий” ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээний нэгдсэн дүн

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	2024 оны 8 сар			2024 оны 12 сар	
			Үнэлсэн оноо	Үнэлгээ ний хувь	Хянал тын оноо	Үнэлсэн оноо	Үнэлгээ ний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	11,7	97,5%	10	11	91,7%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10	100%	9	10	100%
3	Тайлагнал мэдээллийн ил тод байдал	6	6	100%	5	6	100%
4	Аудит хяналтын тогтолцоо	6	6	100%	5	6	100%
5	Эрсдлийн удирдлага	8	7	88%	7	8	100%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6	100%	5	6	100%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	7	88%	7	8	100%
8	Компанийн соёл	6	5	83,3%	6	6	100%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	8	80%	8	9	90,0%
		72	66,7	92,6%	62	70	97,2

ДАРХАН НЭХИЙ ХК –ИЙН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дархан нэхий Хувьцаат компанийн засаглалын үйл ажиллагааны тайлан		
НЭГДҮГЭЭР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ		
Төлөөлөн удирдах зөвлөл нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэцтэйгээр ажиллаж байна.		
	Хэрэгжилт	Тайлбар
1	1.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	2 оноо, 100% Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг ТУЗ-ийн 2023 оны 2023 оны 3 сарын 11-ны өдрийн 03 тоот тогтоолоор шинэчлэн баталсан бөгөөд энэхүү журмын 2.7.6; 2.7.8-д гишүүдэд компанийн зардлаар зөвлөлгөө өгөх, сургалтанд хамруулах тухай заасан байгаа. www.nekhii.mn ; цахим хуудас: -хувьцаа эзэмшигчдэд-дүрэм, журам
2	1.2. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна.	2 оноо 100% Нэр дэвшүүлэх хорооны журмыг шинэчлэн баталж хэрэгжүүлж байгаа. Залгамж халааны бодлогын бичиг баримтыг бэлдэж бүрэн хэрэгжүүлэхээр ажиллаж байна.
3	1.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, өөрийн цахим хуудсанд байршуулна.	1 оноо, 50% Компаний тухай хууль, Компаний “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-д тусгаж, мөрдөж ажилладаг.

4	1.4. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримт бичигтэй байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэр зэрэг асуудлыг тусгана.	2 оноо, 100% .	Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн болон түүний дэргэдэх хороодын бүтцийг Компаний тухай хуулийн хүрээнд байгуулсан. ТУЗ-ийн гишүүдийг анх танилцуулахдаа боловсрол, ур чадвар, туршлага зэргийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн дэлгэрэнгүй танилцуулдаг. www.nekhii.mn цахим хуудас: -хувьцаа эзэмшигчдэд-ТУЗ-ийн ҮА-ны журмын 2.7.6-д зааснаар хэрэгжүүлж байна.
5	1.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.	2 оноо 100%.	ТУЗ-ийн гишүүдийг анх томилохдоо компанийн засаглалын сургалтанд заавал хамруулдаг. Мэдлэг, мэдээллийг олгох, шинэчлэх сургалтанд тогтмол хамруулахаар төлөвлөж байна. www.nekhii.mn цахим хуудас: -хувьцаа эзэмшигчдэд-ТУЗ-ийн ҮА-ны журмын 2.7.8-д заасан байгаа.
6	1.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	2 оноо, 100% .	Компаний тухай хуулийн хүрээнд Компаний “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-д энэ талаар тусгайлан заасныг мөрдөж ажиллаж байгаа.
ДҮН (Авбал зохих оноо-12)		11оноо	91,7%
<p align="center">ХОЁРДУГААР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ</p> <p>Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ</p>			

7	<p>2.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болоод төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.</p>	<p>2 оноо, 100%</p>	<p>ТУЗ-ийн бүрэлдэхүүн Компанийн тухай хуулийн 75,4-д заасантай нийцсэн. 2023 оны 03 сарын 11-ны өдрийн ТУЗ-ын 03 тоот тогтоолоор ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг батлан хэрэгжүүлж байна. ТУЗ-ийн гишүүдийн олонхыг хараат бус байлгах бодлогыг хэрэгжүүлэхээр зорьж байна.</p>
8	<p>2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.</p>	<p>2 оноо 100%.</p>	<p>Аудитын хороо үйл ажиллагааны журамтай, бие даасан хараат үйл ажиллагаа явуулдаг.</p>
9	<p>2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.</p>	<p>2 оноо 100%.</p>	<p>Цалин урамшууллын хороо үйл ажиллагааны журамтай, бие даасан үйл ажиллагаа явуулдаг.</p>
10	<p>2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.</p>	<p>2 оноо 100%.</p>	<p>Нэр дэвшүүлэх хороо үйл ажиллагааны журамтай, бие даасан үйл ажиллагаа явуулдаг.</p>

11	2.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.	2 оноо 100%.	Одоогоор байнгын Стратеги, бодлого төлөвлөлтийн болон үйл ажиллагааны гүйцэтгэлийн хяналтын гэсэн 2 хороог байгуулан ажиллаж байна Эдгээр хороод нь тус бүр үйл ажиллагааны журамтай. Журмыг 2023 оны 3 сарын 11-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар баталсан.
ДҮН (Авбал зохих оноо-10)		10 оноо	100%
ГУРАВДУГААР ЗАРЧИМ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ			
Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана			
12	3.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	2 оноо, 100%	МХБ-ийн цахим хуудаснаа мэдээллээ тогтмол, хугацаанд нь явуулж байгаа.
13	3.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	2 оноо, 100%	Хэрэгжүүлж байгаа.
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	2 оноо, 100%	Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь хараат хараат бус, үнэн зөв мэдээллийг агуулсан, зорилго, зорилтууд, эрсдлээ оруулж тооцсон мэдээлэл байгаа, сайжруулах шаардлага байгаа.
ДҮН (Авбал зохих оноо-6)		6 оноо	100%
ДӨРӨВДҮГЭЭР ЗАРЧИМ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО			
Төлөөлөн удирдах зөвлөл нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана			

15	4.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, журмын хэрэгжилтэд хяналт тавина.	2 оноо, 100%	ТУЗ-ийн Аудитын хороо нь аудитын компанийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, хариуцлага тооцох нөхцлөөр бүрэн хангагдсан.
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	2 оноо, 100%	Ирэх жилийн хувьцаа эзэмшигчдийн хуралд хөндлөнгийн аудиторыг оролцуулж мэдээллийг нь сонсож, хэрэгжүүлнэ.
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж тэдгээрт орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэнэ.	2 оноо, 100%	Энэ мэдээллийг тогтмол мэдээлж байна.
ДҮН (Авбал зохих оноо-6)		6 оноо	100%
ТАВДУГААР ЗАРЧИМ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА			
Төлөөлөн удирдах зөвлөл нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина			
18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.	2 оноо, 100%	Компани нь эрсдэлийн удирдлагыг өөрийн түвшинд хэрэгжүүлж ажилладаг бөгөөд Эрсдэлийн удирдлагыг ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороонд хариуцуулан хэрэгжүүлж байна. Эрсдэлийн удирдлагын талаар Аудитын хорооны журамд заасан байгаа.
19	5.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.	2 оноо, 100%	Компаний ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороогоороо дамжуулан эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж байгаа ба "Компанийн засаглалын кодекс" –ыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор тусгай хороо байгуулах талаар судалж байна.

20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	2 оноо, 100%	Байгаль орчны орон нутгийн газартай байнга холбоотой ажиллаж, тус байгууллагын үзлэг, шалгалт, зөвлөлгөөнд хамрагдаж, тайлан мэдээгээ ил тод тайлагнаж ажилладаг.
21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.	2 оноо, 100%	Сайжруулах бэлтгэл ажил хийгдэж байна.
ДҮН (Авбал зохих оноо-8)		8	100%
ЗУРГААДУГААР ЗАРЧИМ. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ			
Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна			
22	6.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	2 оноо, 100%	2023 оны 03 сарын 04-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар нээлттэй хэлэлцүүлж батлуулан хэрэгжүүлж байна.
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримт бичигт тусгана.	2 оноо, 100%	Компаний ТУЗ-ийн хурлаар нээлттэй хэлэлцүүлж батлуулж хэрэгжүүлж байна.
24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	2 оноо, 100%	Компаний тайланд тусган www.nekhii.mn цахим хуудсаар дамжуулан мэдээлж байгаа
ДҮН (Авбал зохих оноо-6)		6 оноо	100%
ДОЛООДУГААР ЗАРЧИМ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ			
Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ			

25	7.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	2 оноо, 100%	Компанийн засаглалын кодекс" –ыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Байгууллагын соёлыг төлөвшүүлэн хэрэгжүүлэн ажиллахыг зорьж байна.
26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	2 оноо, 100%	Компанийн засаглалын кодекс" –ыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Байгууллагын соёлыг хэрэгжүүлэн ажиллаж байна.
27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	2 оноо, 100%	www.nekhii.mn цахим хуудсаар дамжуулан хөгжүүлэлт хийж үр дүнтэй ажиллуулж байгаа
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	2 оноо, 100%	Санал гомдлын журмыг баталж, хэрэгжүүлж байгаа. Журмыг www.nekhii.mn цахим хуудсанд байршуулсан.
ДҮН (Авбал зохих оноо-8)		8 оноо	100%
НАЙМДУГААР ЗАРЧИМ. КОМПАНИЙН СОЁЛ			
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно			
29	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор төлөөлөн удирдах зөвлөл нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	2 оноо, 100%	Ёс зүйн дүрмыг баталж, хэрэгжүүлж байгаа. Журмыг www.nekhii.mn цахим хуудсанд байршуулсан.
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг төлөөлөн удирдах зөвлөл, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх "шүгэл үлээгчийн" тогтолцоотой байна.	2 оноо, 100%	Хороодын журамд шүгэл үлээгчийн тогтолцооны баримтлах журмыг тусган хэрэгжүүлж байна.

31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	2 оноо, 100%	Ёс зүйн дүрмийг батлан хэрэгжүүлж байгаа. Журмыг www.nekhii.mn цахим хуудсанд байршуулсан.
ДҮН (Авбал зохих оноо-6)		6 оноо	100%
ЕСДҮГЭЭР ЗАРЧИМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ			
Компани болон төлөөлөн удирдах зөвлөд нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана			
32	9.1. Компани хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад зориулан өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан тухай бүр хүргэнэ.	2 оноо, 100%	МХБ-ийн цахим хуудаснаа мэдээллээ тогтмол, хугацаанд нь явуулж байгаа.
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	2 оноо, 100%	Хөрөнгө оруулагчидтай харилцан мэдээлэл солилцох хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа. www.nekhii.mn цахим хуудсанд байршуулсан.
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.	2 оноо, 100%	Компаний тухай хууль, СЗХ-ны журмын дагуу хэрэгжүүлж ажиллаж байгаа
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	2 оноо, 100%	Компаний тухай хууль, СЗХ-ны журмын дагуу хэрэгжүүлж ажиллаж байгаа
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба түүний хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	1 оноо, 50%	Компаний тухай хууль, СЗХ-ны журмын дагуу хэрэгжүүлж ажиллаж байгаа
ДҮН (Авбал зохих оноо-10)		9	90,0%
НИЙТ ДҮН(Авбал зохих оноо-72)		70	97,2%

Санамж:

Компани нь засаглалын зарчмуудыг Монгол Улсын үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасаа бүртгүүлсэн бүх хуулийн этгээд хэрэгжүүлнэ.

Тухайлбал, "МХБ" ХК-ийн 1-р ангилалд бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь кодексийн зүйл тус бүрээр энэхүү маягтын дагуу хэрэгжилт, эсхүл тайлбарыг бүрэн, 2-р ангилалд бүртгэлтэй этгээд 95 хувийг хангасан байна.

Хэрэв дээр дурдсан шалгуурыг хангаагүй буюу хэрэгжүүлээгүй эсвэл тайлбарлаагүй тохиолдолд Тухайн ХК-ийн МХБ-ийн бүртгэлийн ангиллыг бууруулах үндэслэл болох ба нөгөө талаас хөрөнгө оруулагч шийдвэр гаргахад нөлөөлөх шалтгаан болно.

ДҮН: 70 ОНОО буюу 97,2%

Хавсаргасан нотлох баримтууд

1. ТУЗ-ийн ажлын албаны товч тайлан 2024 он
2. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын 2024 оны ажлын тайлан
3. ТУЗ-ийн нарийн бичгийн анкет, засаглалын гэрчилгээний хуулбар
4. ТУЗ-ийн гишүүдийн анкет, засаглалын гэрчилгээний хуулбар
5. ТУЗ-ийн 2024 оны 04 сарын 20-ны өдрийн 24/10 тогтоол, тогтоолын хавсралтууд:

хавсралт1

-ТУЗ-ийн гишүүдийн шинэчлэн батласан ажил үүргийн хуваарь,
/ТУЗ-ийн гишүүдийн ажил дүгнэх заавар, үнэлгээ, урамшуулал/

хавсралт2

-Дархан нэхий ХК-ийн хувьцаа эзэмшигчидтэй харилцах бодлогын бичиг баримт

хавсралт3

-Дархан нэхий ХК-ийн оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогын бичиг баримт -